

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ


Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 21 дүгээр тэмдэглэлд:

“XVIII.2. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дунг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1.Хөвсгөл, Завхан, Архангай аймаг бодлогын баримт бичгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дунгээр хэрэгжилт хангалтгүй буюу хэрэгжээгүй арга хэмжээ тус бүрийг хяналтдаа авч, тодорхой ажил зохион байгуулж, үр дүнг эргэн тайлгахыг Хөвсгөл, Завхан, Архангай аймгийн Засаг дарга нарт үүрэг болгов;

2.Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга хэлбэрийг өөрчилж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үр дунд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд даалгав;

3.Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР